



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 601

Улаанбаатар хот

**Үл хөдлөх хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Иргэний хуулийн 109, 110 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Жи-Мобайл" хязгаарлагдмал хариуцлагатай компаниас авах авлагад тооцон тус компанийн санал болгож хүлээлгэн өгөхөөр тохиролцсон нийт 1,444,000,000.00 (нэг тэрбум дөрвөн зуун дөчин дөрвөн сая) төгрөгийн үнэлгээ бүхий хавсралтад заасан 177 км урттай газрын шилэн кабелийн байгууламжийг хүлээн авч "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаярт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. "Жи-Мобайл" хязгаарлагдмал хариуцлагатай компаниас хүлээлгэн өгсөн шилэн кабелийн байгууламжийг хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтаар шилжүүлэн авах;

2.2. "Жи-Мобайл" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэр дээр байгаа үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэр дээр баталгаажуулах ажлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

2.3. Шилэн кабелийн байгууламжийн дагуух хамгаалалтын зурвас газрын эрхийг "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэр дээр баталгаажуулах асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

2.4. Газар эзэмших эрхийг баталгаажуулсны үндсэн дээр газар эзэмших эрхийн үнэлгээг тогтоож данс бүртгэлд тусгах арга хэмжээг зохион байгуулах;

2.5. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.6. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

132006973

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны... дугаар сарын...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



“МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Эхлэлийн цэг	Төгсгөлийн цэг	Ашиглалтад орсон огноо	Нийт урт /км/	Бүртгэх үнэ
1	Газрын шилэн кабель /Дорнод/	Дорнод аймаг Чойбалсан сумын холбооны байр	Хавиргын боомт	2017.06.27	91	682,000,000.00
2	Газрын шилэн кабель /Архангай, Хөвсгөл/	Архангай аймгийн Цахир сумын холбооны байр	Хөвсгөл аймгийн Жаргалант сумын холбооны байр	2018.08.17	86	762,000,000.00
Нийт дүн					177	1,444,000,000.00
					(нэг тэрбум дөрвөн зуун дөчин дөрвөн сая)	